



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2019 оны 05 сарын 31 өдөр

Дугаар A/385

Арвайхээр

Үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1, 47 дугаар зүйлийн 47.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Жудо бөхийн дэвжээ нийлүүлэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга: Н.Ганболд -Аймгийн Засаг даргын дэргэдэх
Орон нутгийн өмчийн газрын дарга

Нарийн бичгийн дарга: Т.Эрдэнэсүрэн -Аймгийн Засаг даргын дэргэдэх
Орон нутгийн өмчийн газрын худалдан авах

ажиллагаа хариуцсан ахлах мэргэжилтэн

Гишүүд: Н.Дулам -Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт,
хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн

В.Ганцэцэг -Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ахлах
ажилтан

Ш.Авирамд Бүтээлч хөгжлийн хөтөч ТББ-ын гишүүн (зөвшилцөнөөр)

2. Худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, мэдэгдэл, гэрээний төслийг өргөн мэдүүлэхийг Үнэлгээний хороо (Н.Ганболд)-д даалгасугай.

3. Тендер шалгаруулалттай холбоотой баримт бичгээр хууль тогтоомжийн дагуу архивын нэгж бүрдүүлж, Архив, бичиг хэргийн ажилтанд хүлээлгэн өгөхийг Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (Т.Эрдэнэсүрэн)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Г.ГАНБОЛД



011100624

D:My Doc. Zahiramj. Zasag darga